

## **ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

*/9 дүгээр анги удирдсан багшаас эцэг эхэд зориулсан сургалтын модуль/*

*С.Наранзул*

*/Нийслэлийн 32 дугаар сургуулийн сургалтын менежер/*

[naranzul0505@gmail.com](mailto:naranzul0505@gmail.com)

**Модулийн зорилго:** Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн багшаас АМЧБО үйл ажиллагааг зохион байгуулахад эцэг эхийн оролцоог хангах, хүүхдийнхээ суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход зөвлөн туслахад нь арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

**Модуль хэрэгжүүлэх зөвлөмжийн агуулга:** Үүнд:

1. АМЧБО үйл ажиллагааг сурагч, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулах эрх зүйн актууд
2. Эцэг эхчүүдэд танилцуулах суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжааны тухай ойлголт
3. Эцэг эхийн АМЧБО мэдлэг хандлага, оролцоог сайжруулахад багшийн үйл ажиллагаанд өгөх зөвлөмж
4. 9-р ангийн АМЧБО агуулга болох “ Мэргэжил сонголтын 7 хоног” үйл ажиллагааны хүрээнд эцэг эхийн мэдлэг, чадвар, оролцоог хангах
5. Багшийн уншиж судлах гарын авлага, цахим хөтөчийн жагсаалт

**Модуль хэрэгжүүлэх зөвлөмж**

### **1.АМЧБО үйл ажиллагааг сурагч, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулах эрх зүйн актууд**

БШУ-ны Сайдын 2007 оны 351 дүгээр тушаалаар батлагдсан “ЕБС-ийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”-ын ажлын байрны үндсэн зорилтын 2-т багшийн бусад ажлыг гүйцэтгэхэд сурагчид, насанд хүрэгчидтэй ажиллах, сургалтаас гадуурх төрөл бүрийн үйл ажиллагаанд менежемент хийх, 1 дүгээр зорилтын хүрээнд сурагчдынхаа хэрэгцээ сонирхолыг судлах, 2 дугаар зорилтын хүрээнд эцэг эх, иргэд , олон нийттэй ажиллах гэж заасан.

БШУ-ны Сайдын 2020 оны А/199 дүгээр тушаалаар батлагдсан “ Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийн 3 дугаар хэсгийн 7 дугаар заалтад боловсролын байгууллагуудтай хүмүүжлийн асуудлаар хамтран ажилладаг, эцэг эхийн болон олон нийтийн бусад байгууллагын ажиллагааг хөхүүлэн дэмжих, 8 дугаар заалтад нийгмийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх гэж заасан

ХНХЯ болон БСШУСЯ-ны сайдын хамтарсан тушаалаар 2016 оны 6 сарын 24-ний өдөр “Ажил мэргэжлийг чиг баримжааг хөгжүүлэх” чиглэл гарсан.

**АУБ –ААС ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ТАНИЛЦУУЛАХ СУРАГЧИЙН СУРАХ ЧИГЛЭЛ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, МЭДЭЭЛЭЛ**

АУБ нь сурагчид болон тэдний эцэг эхчүүдэд мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулахаас өмнө 8-9 дүгээр ангийн сурагчийн дасгал ажлын ном, багшийн гарын авлага, сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж тус бүртэй нарийвчлан танилцаж судалсан байхаас гадна ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэж юу вэ?, Яагаад чухал болох, эцэг эхийн оролцоо, дэмжлэгийн талаар дараах мэдлэг мэдээллийг уншиж ойлгоорой.

### Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэж юу вэ? Яагаад чухал болох тухай

Хүний амьдралын хамгийн чухал сонголтын нэг нь ажил мэргэжлийн сонголт юм. Ажил мэргэжлээ зөв сонгосноор тухайн хүүхдийн амьдралын чанар, цаашилбал улс орны хөгжилд сайнаар нөлөөлнө.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хөдөлмөрийн зах зээл илүү төвөгтэй, өрсөлдөөнтэй болж, иргэдээс илүү өндөр түвшний ур чадвар, чадамж шаардах боллоо. Иргэд өөрийн сонирхол, ур чадвар, чадамж, эзэмшсэн мэргэжил болон хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн боловсрол, сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн сонголт хийх, ухаалаг шийдвэр гаргах, шийдвэр гаргахдаа янз бүрийн мэдээлэл ашиглах, эдгээр мэдээллийн үнэн зөв, шинэлэг байдалд дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд “Дээд боловсролтой боловч ажил хөдөлмөр эрхлэх мэргэжлийн ур чадваргүй” иргэдийн асуудал нэлээд түгээмэл байна. Гэтэл хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчид дээд боловсролтой гэхээс илүүтэй чадамжтай мэргэжлийн ажилчид хэрэгтэй байгаа талаар мэдээлсэн байдаг. Энэ асуудал ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чухал асуудлыг өөрийн эрхгүй хөндөхөд хүргэдэг.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэдэг нь суралцагчдыг ажил мэргэжлийн төлөвлөлт хийх, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх тухай ойлголт юм. Тиймээс үүнийг дараах байдлаар тодорхойлж болно: “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэдэг нь суралцагчдад ажил мэргэжилтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, оновчтойгоор үйл хэрэг болгон хэрэгжүүлэхэд дэмжиж тусалдаг бүхий л үйл явц юм”.

АМЧБО нь хэдийгээр манай улсын хувьд шинэхэн ойлголт хэдий ч дэлхийн олон эрдэмтэд шинжлэн судалж, онолын ойлголтуудыг дэвшүүлсэн байна. Эрдэмтэн Гинсберг (1951), Доналд Супер (1990) нарын дэвшүүлсэн “Хөгжлийн онол” нь ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвших үйл явцыг хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үе шаттай холбон тодорхойлсон. Энэ нь ажил мэргэжлийн чиг баримжааны үе шатууд нь суралцагчдын бага, дунд, ахлах сургууль болон сургууль төгссөний дараах насны онцлогоос хамаардаг учир тухайн үе тус бүрт тохирсон суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Хөгжлийн онолоор ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвшихийг 10-11 орчим насны хүүхэд тоглодог тоглоом, дуртай зүйлээрээ дамжуулан мөрөөдлийн, 12-13 орчим насны хүүхэд өөрийн чадвар, давуу талаа мэдэрсэн, 15-16 насны хүүхэд өөрийн зорилго, үнэт зүйлийг илүүд үзсэн, 17-18 насандаа ирээдүйн төлөвлөлтийг харгалзахыг хичээсэн” үе хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийн сэтгэлгээ, танин мэдэхүйн хөгжлийн үе

шаттай ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших хөгжлийн үе шат маш нягт уялдах учиртай ажээ. Эдгээрийг уялдуулан хөгжүүлээгүй тохиолдолд тодорхой нэг үе шатанд “гацах” хандлага их байдаг байна. Тиймээс суралцагчдыг танин мэдэхүйн хөгжлийн үе шатны дагуу суралцах үйл явцад чиглүүлэх нь тэднийг ажил мэргэжлээ илүү бодит, ухаалаг сонголт хийх чадварт сургадаг байна.

Иймээс ЕБС-ийн дунд ангиас эхлэн ирээдүйн ажил мэргэжлээ өөрийн сонирхол, ур чадвар, эрхэмлэдэг үнэт зүйл болон хувь хүний шинж чанарт тохируулан сонгох явдал хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, хэрэгцээ шаардлагатай уялдсан, бүтээмжтэй ажиллах хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэ нь суралцагчдын ажил мэргэжлийн болоод сургалтын сонголтгоо ухаалгаар хийх, боломжийг зөв тооцоолж, богино, дунд болон урт хугацааны зорилтоо тодорхойлох, төлөвлөлт хийх боломжийг олгоно. Түүнчлэн ЕБС-ийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг үр дүнтэй олгосноор тэдний сургалтын болон мэргэжлийн сонголтын чанарыг сайжруулах ба ингэснээр сурах үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах, сурлагын амжилт сайжрах үндэс болдог (Lapan, Gysbers & Sun, 1997).

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дэх ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс 2016 оны 6 сарын 24-ний өдөр ХНХЯ болон БСШУСЯ-ны сайдын хамтарсан тушаалаар “Ажил мэргэжлийг чиг баримжааг хөгжүүлэх” чиглэлийг баталсан байдаг. Энэхүү чиглэлээр ажил мэргэжлийг чиг баримжаа олгох үйлчилгээ нь “иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтгоо хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх” зорилготой

2015-2017 онд БСШУСЯ нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн 4-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ЕБС-ийн 8, 9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжааны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тэр дундаа 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн “Сонголтын 7 хоног”-ийн үйл ажиллагааг бүх сургуульд зохион байгуулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжааг ЕБС-д хэрэгжүүлэхдээ сурагч, багш, сургуулийн үйл ажиллагаанаас гадна эцэг эхийн хандлага, оролцоог сайжруулах нь уг ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.

Зарим орны судлаачдын (жишээ нь Vu Tuan Anh, 2014) цохон тэмдэглэснээр дээд боловсролтой иргэд ажилгүй байгаагийн үндсэн шалтгаан нь тэдний өөрсдийн эсвэл эцэг эхийн хийсэн ажил мэргэжлийн алдаатай сонголт байдаг.

ЕБС-ийн суралцагчид ажил мэргэжлийн сонголтгоо хийхдээ эцэг эхтэйгээ ярилцдаг хэдий ч тэд нийтлэг бөгөөд хуруу дарам цөөн ажил мэргэжлийн ойлголттой, мөн АМЧБО талаар мэдлэг маш сул байдаг тул зөв сонголт хийж чаддаггүй байна. Иймд АМЧБО үйл ажиллагаанд зөвхөн суралцагчид төдийгүй эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлж, оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй юм.

- АМЧБО талаар эцэг эхийн мэдвэл зохих мэдлэг, хандлага болон хийж болох, хийж болохгүй зүйлсийн тухай

Эцэг эх бүхэн хүүхдийнхээ ирээдүйн ажил мэргэжил, санхүүгийн аюулгүй байдлыг хангахын төлөө цаг үргэлж санаа тавьсаар байдаг. Хүүхэд ерөнхий боловсролын сургуулиа төгсч, амьдралын чухал сонголтын нэг мэргэжил сонголтоо хийнэ. Гэвч ямар байр сууринаас хандахаа мэдэхгүй байдал ихэнх эцэг эхэд тохиолддог. Тэд хүүхэддээ ажил мэргэжлийн сонголт, АМЧБО мэдлэг мэдээллийг эртнээс олгох талаар мэдлэг мэдээлэлгүй байх, зөвхөн ЭЕШ-ийн оноон дээр суурилж, ажил мэргэжил, суралцах сургуулийг сонгож байгаа нь учир дутагдалтай байна.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, ажил мэргэжил сонголтод эерэг болон сөргөөр нөлөөлж байдаг аж.

Эерэг гэдэгт шүүмжлэлт сэтгэлгээгүй, хүүхдийнхээ ярьж хүсч байгаа зүйлийг байгаагаар нь хүлээн авч дэмжихийг хэлэх бол сөргөөр гэдэгт өөрийн үзэл бодлоо тулгах, бусадтай харьцуулах, хүсэл сонирхлыг нь үл хайхрах зэрэг үйлдлүүд багтдаг. Мэргэжил сонголтод таны оролцоо нэн чухал. Тэгвэл хэрхэн мэргэжил сонголтод нь эерэгээр нөлөөлж болох вэ?

- Шийдвэр гаргахад нь дэмжиж оролцох
- Хүүхдийнхээ шийдвэрийг хүндлэх
- Тулган шаардахгүй байх
- Хүүхэддээ чадвараа олж илрүүлэх эрх чөлөө, цаг хугацааг өгөх
- Хүсэл сонирхлоо олсон үед нь хөгжүүлэх, зорилгодоо хүрэх сэдэл өгөх
- Амжилт бүтэлгүйтлийн алинд ч хоосон магтаалаас илүү урам өгөх
- Хариуцлагатай хандлага төлөвшлийг олгох
- Шүүмжлэлээ урьтал болгохгүй өөртөө итгэх итгэлийг өгөх
- Үлгэр дууриаллыг үргэлж таниас авдгийг санаж, алдаа дутагдлыг зөвшөөрч, өөрийн туршлагыг ярьж, нээлттэй харилцаарай.

#### Хүүхдийнхээ хүсэл сонирхлыг эхлээд асуу

Таны хүүхэд ирээдүйгээ хэрхэн харж, төсөөлж байгаа талаар нээлттэй ярилцаарай. Хүн бүрийн авъяас, ур чадвар харилцан адилгүй. Түүний хүсэл сонирхол хаашаа ч чиглэсэн бай таны шаардлагад үл нийцсэн ч бай энэ л үед хүүхдийнхээ хамгийн сайн сонсогч нь байх хэрэгтэй. Эцэг эхчүүд ихэнхдээ хүүхдээ өөрийнх нь алдааг битгий давтаасай гэж хүсдэгээсээ болж өөрийн хүсэл, шаардлагыг тулгаснаар өөрсдөө “алдаж” эхэлдэг. Хүүхдийнхээ сонирхлыг нэгт тавьснаар их сургуульдаа амжилттай оюутан байх эхний алхам юм. Шүүмжлэлгүй ярилцсанаар хүүхдийнхээ давуу тал, өрсөлдөх чадварыг өөрсдөдөө нээх боломжийг олгоорой.

#### Хүүхдийнхээ авъяас, ур чадварт суурилан зөвлөөрэй

Өөрийн хийхийг хүссэн зүйлээ, бүтээж чадах ур чадвартайгаа уялдуулан мэргэжлээ сонгосон хүүхэд илүү амжилттай суралцаж, амжилттай төгсдөг байна. Ур чадварт авъяасаас гадна зөөлөн гэгддэг уян хатан зохицох, багаар ажиллах, асуудлыг шийдвэрлэх зэрэг чадварууд багтдаг бол орчин үед IQ өндөртэй гэхээсээ EQ буюу сэтгэл хөдлөлөө удирдаж чаддаг хүмүүс илүү өндөр амжилтанд хүрдгийг 1995 онд Даниел Големан гарган ирснээр хаана ч яригдах болсон. Тиймээс ур чадвар, сэтгэл хөдлөлийн хэв шинжээ тодорхойлуулан, зан төлөвт нь ямар мэргэжил тохирох талаар хамтдаа судлаарай. [Эх сурвалж: www.idreamcareer.com](http://www.idreamcareer.com)

#### Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан зөвлөх

Дэлхий дахин техник технологийн хөгжлөөр хурдацтай хөгжиж байгаа энэ цагт өнөөдөр сонгосон мэргэжил ойрын хэдэн жилдээ эрэлттэй байж, хэдэн жилийн дараа устахыг хэлж мэдэхэд хэцүү болсон цаг. Хиймэл оюун ухаан энэ эрчээрээ хурдацтай өсвөл үйлдвэрлэлийн процесст хүний гар хүрэх шаардлагагүй бол робот орлож, зарим

мэргэжлүүд устгах нь тодорхой болсон. Харин эсрэгээрээ дэлхий дахинаа сувилахуй, эмнэлгийн ажилтан, үйлчилгээ, мэдээллийн технологийн салбарт мэргэжилтнүүдийн ач холбогдол өндөр байна. Сонирхсон ажил мэргэжилтэй нь холбоотой мэргэжилтнүүдтэй уулзуулахад эргэлзээг арилгаж, хүсэл эрмэлзлийг нь өдөөж өгдөг байна. Судалгаагаар ажил мэргэжлээ сонгоход эцэг эхийн оролцоо, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал нь хүүхдийг өөртөө итгэлтэй, ирээдүйд хэзээ ч орхихгүй ажил мэргэжлээ амжилттай сонгосныг харж болох юм. ([Эх сурвалж: www.ncda.org/Keller.2004](http://www.ncda.org/Keller.2004))

Тиймээс хүүхдүүдийнхээ мэргэжил сонголтод эцэг эхчүүдийн ХИЙЖ болох мөн ХИЙЖ БОЛОХГҮЙ зүйлсийн жагсаалтыг хүргээрэй.

| <b>Эцэг эхийн хийж болох зүйлс</b>  | <b>Эцэг эхийн хийж болохгүй зүйл</b>  |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийнхээ давуу болон сул ур чадварыг нь хамтдаа үнэл</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд тань ямар ч шийдвэр гаргасан бүү зэмлэ, зөв шийдвэр гаргахад нь чиглүүлээрэй</li> </ul>   |
| <ul style="list-style-type: none"> <li>Өөрийн хүсэл тэмүүллийг олж илрүүлэхэд нь туслаарай</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>Ажил мэргэжлийн талаарх өөрийн төсөөлөл, өнгөц дүгнэлтийг бүү хий! /Хүүхдүүд тодорхойгүй нийгэмд амьдарч байна. Бидний буюу өмнөх үеийн ажил хөдөлмөрийн өнгө төрх, одоогийн хүүхдүүдийн үед өөр байх болно/.</li> </ul> |
| <ul style="list-style-type: none"> <li>Хүсэл мөрөөдлөө хэрэгжүүлэхэд сэдэлжүүл</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийнхөө итгэл үнэмшил, үзэл бодлоо хүүхэддээ бүү тулга!</li> </ul>   |
| <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдэдээ ажил мэргэжлийн ертөнцийн талаар мэдээллээр хангах</li> </ul>                                      | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийнхөө биелүүлж чадаагүй хүсэл мөрөөдлөө хүүхдээрээ хийлгэх гэж бүү оролд! /Манай гэр бүлийн уламжлал, эсвэл би эмч болох гээд чадаагүй тул чи миний мөрөөдлийг биелүүл гэх мэт/</li> </ul>                           |
| <ul style="list-style-type: none"> <li>Сонирхож буй мэргэжлээр нь төгссөн, ажиллаж байгаа мэргэжилтнүүдтэй холбоо тогтоон хамтдаа уулзах</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийнхээ хүсэл сонирхлыг хэтэрхий бүү хяна! Хүүхдийн ажил мэргэжлийн талаарх санал бодол хүсэлт мөрөөдлийг бүү няцаа бүү үгүйсгэ!</li> </ul>  |
| <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийнхээ итгэлийг олж, асуулт асуух бүрт нь урамшуул</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийнхээ өмнөөс дангаараа бүү шийдвэр гарга</li> </ul>  |
| <ul style="list-style-type: none"> <li>Шаардлагатай бол хамтдаа мэргэжлийн сэтгэл зүйчид хандах</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>Хүүхэдтэйгээ харьцахдаа тэвчээргүй хандаж болохгүй</li> </ul>  |
| <ul style="list-style-type: none"> <li>Тэднээр юу хийснээр нь бахархаж байгаа үргэлж хэлж урамшуул.</li> </ul>                                      | <ul style="list-style-type: none"> <li>Хүүхэддээ нөлөөлөх гэж бүү оролд! / “Бидний үед ийм байгаагүй” гэж бүү тулгаарай. Бидний мэддэг ажил мэргэжлийн боломжууд тэдний үед өөрчлөгдсөн байх болно гэдгийг сана/</li> </ul>                                     |

|   |  |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эх өөрөө ажил мэргэжлийн чиглэл, сонголтын талаар мэдлэг мэдээлэлтэй болох, хамтдаа судлах</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжил сонголтын тал дээр цаг зав гаргаад судлаад мэдэх зүйл дээр мэдэхгүй гэж хариулж урмыг нь бүү хугалаарай</li> </ul> |
|---|--|

Мэргэжил сонгоход эцэг эхийн үүрэг, оролцоо нь чухал болохыг бид мэдэж авлаа. Хүүхдүүд эцэг эхдээ өөрийн сонирхол, хүслээ ойлгуулмаар байвч эцэг эх нь энэ хэрэгцээг нь ойлгож чадахгүй бол хоорондын үл ойлголцол улам бүр нэмэгдсээр байдаг. Хүүхэд тань буруу сонголт хийх, магадгүй алдаа гаргахад та уурлахаас илүүтэй тэдэнтэй тэвчээртэй, нээлттэй ярилцах нь таны үүрэг, оролцоо болж чадах юм. Хүүхдийнхээ хүсэл сонирхол цаг үеэ дагаад өөрчлөгдөж байгааг мэдэрч, тэдний сонирхолд нийцэх ажил мэргэжлийн сонголтыг санал болгоорой.

### **3. АМЧБО ТАЛААРХ ЭЦЭГ ЭХИЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХАД БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

- Эцэг эхийн оролцоог хангах “Үйл ажиллагааны төлөвлөгөө” гаргах
- 8-9-р ангийн үйл ажиллагааны жишиг төлөвлөгөөг эцэг эхийн оролцоотой хэрэгжүүлэх/ Багшийн гарын авлага 8-10-р анги 73 дугаар хуудас/
- Эцэг эхийн хурал дээр АМЧБО гэж юу вэ? Яагаад чухал болох талаар хичээлийн жилд 2-оос доошгүй удаа сургалт, өдөрлөг зохион байгуулах
- “ Мэргэжил сонголтын 7 хоног”-ийг ангийн түвшинд болон бусад багш нартай хамтран зохион байгуулах
- “Мэргэжил сонголтын 7 хоног”-т эцэг эхийн оролцоог хангах, мэдээллийг хүргэх
- Эцэг эхчүүдэд сурагчийн гарын авлагын даалгавар дасгалыг хамтдаа ажиллах зөвлөмж өгөх
- Ангийн түвшинд АМЧБО/ ажил мэргэжлийн чиглэл/ үйл ажиллагааны талаар төлөвлөгөө гарган, түүний биелэлтэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Ангийн сурагчийн авьяас чадварын талаар эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл хүргэж мэргэжлээ сонгох, шийдвэр гаргахад хамтран мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
- Ажил мэргэжил, хичээлийн уялдааг ойлгуулах мэдээлэл хүргэх
- Сурагчдын судалгаанд үндэслэн хичээлийн сонголт хийхэд, эцэг эхтэй хамтран зөвлөн туслах
- Эцэг эхэд ажил мэргэжил сонгох хичээлийн талаар ганцаарчилсан зөвлөгөө өгөх
- Ажил мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулах багт тухайлсан эцэг эхийг оролцуулж болно
- Сургуулийн номын санд ажил мэргэжлийн булан ажиллуулахад тэцэг эхийг сайн дураар оролцуулж болно
- Анги танхимын сургалтад ажил мэргэжилтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажил даалгаж болно.

#### 4.9 ДҮГЭЭР АНГИЙН АМЧБО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АГУУЛГА БОЛОХ “МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН 7 ХОНОГ”-ИЙН ХҮРЭЭНД ЭЦЭГ ЭХИЙН МЭДЛЭГ ЧАДВАР, ОРОЛЦООГ ХАНГАХ

9 дүгээр ангийн АМЧБО үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээ / Сурагч, эцэг эхийн оролцоо/

| № | Чадамж                       | Сурагч | Эцэг эх |
|---|------------------------------|--------|---------|
| 1 | Өөрийгөө ойлгох              |        |         |
| 2 | Ажлын ертөнцийг ойлгох       |        |         |
| 3 | Нөлөөллийг ойлгох            |        |         |
| 4 | Ажил мэргэжлийн зорилго      |        |         |
| 5 | Сонголт хийх, шийдвар гаргах |        |         |
| 6 | Үйл хэрэг болгон хэрэгжүүлэх |        |         |

Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны гол бүрэлдэхүүн нь 9 дүгээр ангийн дараагийн хичээлийн жил буюу 10 дугаар ангид судлах хичээл сонгох үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагааг долоо хоногийн хугацаанд багш, эцэг эх, суралцагч хамтдаа хэрэгжүүлэх бөгөөд энэ долоо хоногийн хугацаанд 8-р ангидаа суралцагчид өөрийн сонирхол, чадвар, үнэт зүйлээ таньж мэдсэн зүйлээ эргэн харах бататгах, түүнд үндэслэн ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлох, түүнчлэн өөрийн суралцах чиглэлийн төлөвлөгөө боловсруулах юм.

10 дугаар ангийн хичээл сонгох долоо хоногийн үйл ажиллагааны явцад суралцагчид өөрийн гэсэн **төлөвлөгөөтэй** болно. Энэ төлөвлөгөө нь тэдний ажил мэргэжлийн сонголт дээр үндэслэн хичээлээ сонгон амжилттай суралцах боломжийг олгох юм. Энэ төлөвлөгөөг боловсруулахад сургууль, багш, эцэг эхийн тусламж, дэмжлэг оролцоо зайлшгүй чухал. Үүнээс гадна суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь суралцагчдад сургалт илүү утга учиртай юм байна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлж улмаар суралцахуйдаа хариуцлагатай хандахад ихээхэн ач холбогдолтой. Ингэснээр суралцагчид ирээдүйдээ ухаалаг сонголт хийх боломжтой болох юм.

#### “ ХИЧЭЭЛ СОНГОЛТЫН 7 ХОНОГ” ГЭЖ ЮУ ВЭ?

ЕБС-ийн 9 дүгээр ангийн суралцагчид ирэх хичээлийн жилдээ буюу 10 дугаар ангийн хөтөлбөрийн дагуу ирээдүйн ажил мэргэжлээ баримжаалан хичээлээ сонгон судлах шаардлагатай болдог. 2015-2016 оны хичээлийн жилд БСШУЯ-аас суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг улсын хэмжээнд 9-р ангид хичээл сонгох 7 хоногийг туршсан. Үүнийг “Хичээл сонголтын 7 хоног” гэж

нэрлэдэг. “Хичээл сонгох 7 хоног”-ийн турш багш, эцэг эх, суралцагчид хамтран 10 дугаар ангийн хичээл сонголтыг хийж түүний дагуу суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөө боловсруулах юм.

ЕБС-ийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө заавал судлах, сонгон судлах хэлбэртэй байдаг. Заавал судлах хичээлд бүх хүүхдүүд хамрагдах ба нэмж ахлах 10-12-р ангид 3-4 хичээлийг сонгон судалдаг. Энэхүү сонгон судлах хичээл нь тухайн хүүхдийн сонгосон мэргэжилтэй уялдах ёстой байдаг. 10-р ангид орохоос өмнө өөрийн сонирхол, хувь хүний чадварт уялдуулан мэргэжлээ сонгоод, түүнд холбоотой хичээлээ сонгох гэсэн дараалалаар үйл ажиллагаа явагдана. Хичээл сонголтыг судалгаагүй, ач холбогдлыг ойлгоогүй, эцэг эхийн оролцоогүй хийснээс 12-р анги хүртлээ хэд хэдэн удаа сонголтоо өөрчлөх, сонгосон хичээлдээ идэвхгүй байх хандлага харагддаг.

Анги удирдсан багшийн хувьд АМЧБО олгох ач холбогдлыг эцэг эхчүүдэд ойлгуулах сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага хийх замаар мэдээллээр ханган “Хичээл сонголтын долоо хоног”-ийн үйл ажиллагаанд хүүхдийнхээ хамт оролцох, суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөөг хамтран зөвшилцөж баталгаажуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэ нь эцэг эх, сурагч, багш 3 хамтдаа 10 дугаар ангийн хичээлийн сонголтод хариуцлага хүлээхийг илтгэнэ.

Сонголтын 7 хоногийн явцад 10 дугаар ангид судлах хичээл сонгох үйл явц тэдний ирээдүйн сургалт болон амьдралд ямар чухал болохыг ойлгуулах зорилготой хүүхдийн хийж буй дасгал даалгаврыг хамтдаа ажиллуулахад АУБ-аас анхаарлаа хандуулаарай. Хүүхдийнхээ хийсэн анхны сонголтын талаар сайн ярилцаж, багштай нь ямар сонголт хамгийн зөв, ухаалаг байх талаар ярилцаж зөвлөлдөх, ганцаарчилсан уулзалт хийх нь их ач холбогдолтой.

Мөн багш болон сурагчдад зориулсан гарын авлага, зөвлөмжийг судлан ашиглах зайлшгүй шаардлагатай.

Доорх хүснэгтэд 9-р ангид заавал зохион байгуулах “Мэргэжил сонголтын 7 хоног”-ийн хийгдэх үйл ажиллагааг орууллаа. Энэхүү үйл ажиллагаан дээр зарим бүтээлч ажлуудыг санаачлан зохион байгуулж, үр дүнг нэмэгдүүлээрэй.

| Өдөр | Хийгдэх үйл ажиллгаа      | Хэлбэр, арга зүй  | Хамрах хүрээ      | Ашиглах гарын авлага  |                                     |
|------|---------------------------|---|-------------------|---|-------------------------------------|
| I    | Сонирхлын чиглэлээ сонгох | <ul style="list-style-type: none"> <li>• Сонирхлын чиглэлээ тодорхойлох</li> <li>• Зорилхлын чиглэл дээр үндэслэн хөдөлмөрийн салбарыг сонгох</li> <li>• Хөдөлмөрийн салбараас 2 мэргэжил сонгох</li> </ul> | Бүлгээр хэлэлцэх, | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | Сурагчийн гарын авлагын 7-18 хуудас |
| II   | Өөрийгөө таньж мэдэх      | <ul style="list-style-type: none"> <li>• Дуртай дургүй хичээлээ</li> </ul>  | Бүлгээр           |   | Сурагчийн                           |



|     |  |   |   |   |  |
|-----|--|---|---|---|--|
|     |  | <ul style="list-style-type: none"> <li>• эргэцүүлэх</li> <li>• Өөрийн эзэмшсэн чадваруудаа үнэлэх</li> <li>• Үнэт зүйлээ тодорхойлох</li> <li>• Ажиллах арга барилаа сонгох</li> </ul>                              | Ярилцах<br>Хэлэлцэх                                     | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | гарын авлагын 19-24 хуудас   |
| III | 10-р ангийн хичээл сонголт                 | <ul style="list-style-type: none"> <li>• Туршилтат сонголт хийх</li> <li>• Гэр бүлийнхэндээ танилцуулах</li> </ul>  | Бүлгээр ярилцах хэлэлцэх зөвлөгөө өгөх                  | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | Сурагчийн гарын авлагын 19-24 хуудас   |
| IV  | Гэрийн даалгавар хэлэлцэх                  | <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхтэй ярилцлага хийх</li> <li>• Ажлын арга барил ба хүйсийн онцлог</li> <li>• Ажил мэргэжлийн хариуцлага</li> </ul>   | Бүлгээр ярилцах хэлэлцэх зөвлөгөө өгөх                  | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | Сурагчийн гарын авлагын 25-30 хуудас   |
| V   | Үнэлгээ хийх                               | <ul style="list-style-type: none"> <li>• Суурь түвшний үнэлгээ дахин хийх,</li> <li>• энэ долоо хоногт хийгдсэн үйл ажиллагаануудын давуу болон сул талыг тодорхойлох, хэрхэн сайжруулах талаар хэлэлцэх</li> </ul> | Бүлгээр Ганцаарчилсан Ярилцлага Хэлэлцүүлэг Сонсгол     | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | Сурагчийн гарын авлагын 31 хуудас  |
| VI  | Ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргах          | <ul style="list-style-type: none"> <li>• Өгөгдсөн загварын дагуу ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргах</li> </ul>   | Бүлгээр Ганцаарчилсан Ярилцлага хэлэлцүүлэг             | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагчийн гарын авлагын 32-33 хуудас</li> </ul> |
| VII | Ажил мэргэжлийн төлөвлөгөөг баталгаажуулах | <ul style="list-style-type: none"> <li>• Ажлын төлөвлөгөөг АУБ, суралцагч, эцэг эх хэлэлцэн батлах</li> </ul>   | Бүлгээр Ганцаарчилсан Ярилцлага Хэлэлцүүлэг Танилцуулга | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч</li> <li>• Эцэг эх</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагчийн гарын авлагын 35 хуудас</li> </ul>    |

### 5.Багшийн уншиж судлах гарын авлага, цахим хөтөчийн жагсаалт

- Ажил мэргэжлийн чиг баримжаа ба суралцах чиглэл /ЕБС-ийн 9 дүгээр ангийн сурагчдад зориулсан ажлын дэвтэр/ 2018
- Эцэг эх асран хамгаалагчийн зөвлөмж 2016
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

### Цахим эх сурвалж:

- [www.mergeil.mn](http://www.mergeil.mn)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- [www.onisep.fr](http://www.onisep.fr)
- [www.myworldofwork.co.uk](http://www.myworldofwork.co.uk)
- [www.careers.govt.nz](http://www.careers.govt.nz)
- <https://myfuture.edu.au>
- rilsp.gov.mn
- <http://hudulmur-halamj.gov.mn/occ/show/id/186>
- biznetwork.mn (ажил мэргэжлийн болон ажлын байранд тавигдах шаардлага)
- [www.1212.mn](http://www.1212.mn) (Статистикийн мэдээллийн сангаас цалингийн мэдээлэл авах)
- <https://nationalcareersservice.direct.gov.uk/job-profiles/> (ажил мэргэжлийн талаарх гадаадын цахим эх сурвалжаас мэдээлэл авах)
- <https://www.onetonline.org>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ

